

МОНГОЛЫН СЭТГЭГЧ АГВААН-ИШСАМБУУ СУДЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Т.Булган (Доктор, PhD,
М.Нандинбаатар (Магистрант)
МУИС, ШУС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: Шар үсийг хөдөлгөгч, Эсрүний авхай, Эрдмийн далайд орох онгоц, Бодь мөрийн хөтөлбөр бичиг

Товч утга: Өгүүлэлд монголын сэтгэгч Агваан-Ишсамбуугийн намтар болон зохиол бүтээлүүдийн судалгааны талаар авч үзэв. Түүний зохиол бүтээлүүд судлагдсаар түсгэй судалгааны чиглэл болсон байна. Тэрээр буддын утга зохиол, хэл шинжлэл, философи болон бусад чиглэлээр зохиол бүтээл туурвисан ба Ламримийн чиглэлээр 2 бүтээл бичжээ.

Агваан-Ишсамбуугийн бүтээлүүд нь хэл шинжлэлийн салбарт нэлээд судлагдсан онцлогтой.

* * * * *

“Агваан-Ишсамбуу судлал”-ыг үүсгэсэн, өрнүүлсэн, хувь нэмрээ оруулж буй дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид цөөнгүй байна. Тэдгээрийг эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн он дарааллаар тэмдэглэвэл Ш.Ишпавхай (1958), С.Гомбожав (1959), Ц.Дамдинсүрэн (1959), М.Санждорж (1959), Г.И.Михайлов (88-8), W.Heissig (1913-2005), Л.Хүрэлбаатар (1970), Д.Ёндон (1971), Г.Жамсранжав (1994), Т.Булган (1996), Р.Бямбаа (1996), Ж.Дашдондог (1997), Ш.Сонинбаяр (2008) нар болно. Мөн одоогийн СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэн эл судлалд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа бөгөөд Ш.Сонинбаяр¹, Ж.Болдбаатар², Т.Булган³, М.Бембя⁴, О.Дэмчигмаа⁵, С.Даваабаяр⁶, Д.Ундрах⁷, Б.Жамбал⁸, Я.Ганзаяа⁹, Д.Боролзой¹⁰, Б.Цэвээндорж¹¹, Д.Даваасүрэн¹², Р.Бямбаа¹³, Д.Наранцэцэг¹⁴, Б.Хишигсүх¹⁵, М.Нандинбаатар¹⁶ нар тус хүрээлэнгээс 2012 онд зохион байгуулсан “Эрдэнэ мэргэн бандида Агваан-Ишсамбуу судлалд” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн. Өмнөх судалсан байдлаас үзэхэд, эрдэнэ мэргэн бандида Агваан-Ишсамбуугийн намтрыг гавж, доктор Ш.Сонинбаяр, түүний зохиол бүтээлийг судлаач Р.Бямбаа нар судалсан нь эрдэм шинжилгээ, судалгааны өндөр ач холбогдолтой болсон байна.

¹ Илтгэл: Эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуугийн намтар судлалд., 157 х

² Илтгэл: Булган хангайн номын мэргэд., 160 х

³ Илтгэл: Эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуу буддын гүн ухааны их сэтгэгч маха бандида болох нь., 166 х

⁴ Илтгэл: Story of seven bramins., 174 х

⁵ Илтгэл: Агваанишсамбуугийн зохиол бүтээлийг эх бичиг судлалын үүднээс ажиглах нь., 176 х

⁶ Илтгэл: Мэргэн бандида Агваанишсамбуу ламын зурхайн бүтээл нь махбодын зурхайн онолд тулгуурласан нь., 182 х

⁷ Илтгэл: Гэрээс гарсан тэмдэг бичиг буюу “түтэй” бичгийн тухай., 188 х

⁸ Илтгэл: Агваанишсамбуугийн зарим зохиолыг бодь мөрийн зэргийн үүднээс шинжлэх нь., 192 х

⁹ Илтгэл: Гандантунцоглинд бартай Ии шаврангийн нэгэн зохиолын тухай., 196 х

¹⁰ Илтгэл: Ии гэлэнгийн тухай аман мэдээ., 199 х

¹¹ Илтгэл: Ишсамбуугийн зарим зохиол соёлын зан үйлд холбогдох нь., 201 х

¹² Илтгэл: Бандида Занабадарагийн нэгэн залбиралд хийсэн ажиглалт., 207 х

¹³ Илтгэл: Эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуугийн зохиол бүтээлийн тойм., 215 х

¹⁴ Илтгэл: Эрхэмсэг магтаалын цагаан лянхуаг мөшөөлгөгч эрдмийн далайн мэргэн сартваахь., 220 х

¹⁵ Илтгэл: “Өнчин янзаганы үг” шүлгийн утгыг мөшгих нь., 224 х

¹⁶ Илтгэл: Ишсамбуу ламтаны уугуул хийдийн тухай товч өгүүлэх нь., 154 х

Мөн эрдэмтэн судлаач Л.Хүрэлбаатар түүний зохиол бүтээлийн утгын судалгааг эхлүүлсэн нь төвд хэлээр ном зохиол туурвисан монгол лам нарын судалгааг өргөжихөд дорвитой хувь нэмэр болжээ.

Агваан-Ишсамбуугийн намтар судлалд дээр дурдсан эрдэмтэн судлаачдын бүтээл шууд холбогдохын зэрэгцээ Шаддүвлингийн даяанч лам Лувсангончогдоржийн “bsTan pa’I gsal byed ‘er te ni mer gen pandita hu pil kan bla ma’I gsang ba’I nam thar dang ‘brel ba’I gsol ‘debs dad pa’I spu long gyo byed ces bya ba” [мон: Шашныг тодруулагч эрдэнэ мэргэн бандида ламын нууцын намтартай барилдуулсан залбирал, сүжгийн шар үсийг хөдөлгөгч] (цаашид “Шар үс хөдөлгөгч” гэнэ), Аари хувилгааны “Pandi-ta dzanya’-na baha-dra’I ‘khrungs-rabs dang ‘brel-ba’I gsol-‘debs Mu-tig phreng-ba” [мон: Бандида Занабадрагийн төрөл үе лүгээ барилдуулсан залбирал Сувдан эрхи хэмээх] (цаашид “Сувдан эрхи” гэнэ), Тарган бандида Цэвэлванчүгдоржийн “mChog sprul rin po che grub mchog mkha’ spyod rol pa’I rdo rje ‘khrungs rab gsol ‘debs yon tan rgya mtshor ‘jug pa’I gru gzungs zhes bya ba” [мон: Чогбүрүл ринбүчи дээд бүтээлч Хажодролвийдоржийн төрөл үеийн залбирал Эрдмийн далайд орох онгоц хэмээх оршвой] (цаашид “Эрдмийн далайд орох онгоц” гэнэ) гэх төвд, гар бичмэл сурвалж мөн болно. Эдгээр гар бичмэлийг бүрэн эхээр нь Р.Бямбаагийн 2012 онд хэвлүүлсэн “Жидорын хамба Агваанхайдүвийн хувилгаан шашныг гийгүүлэгч эрдэнэ мэргэн бандида Ишсанбуугийн намтар хийгээд сүмбүмийн бүрэн гарчиг оршивой” хэмээх нь “Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл цувралын VIII-д 126-137 дахь талд хэвлэсэн байна.

Төвд хэлээр зохиол бүтээл туурвисан монгол лам нарыг намтар судлал, шашин судлал, соёл судлал, урлаг судлал, нийгэм соёлын антропологи, утга зохиол судлал, хэл шинжлэл, гүн ухааны үүднээс анхааран, үе улируулан судалсаар байна. Эл судалгааны хүрээнд Агваан-Ишсамбууг яруу найрагч талаас нь түлхүү судалж ирсэн бөгөөд дээр дурдсан олон улсын эрдэм шинжилгээний хурлаас түүнийг “соён гэгээрүүлэгч”, “гүн ухаантан”, “хувилгаан” болох талаас нь илүү ач холбогдол өгөх болсон байна. Эдүгээ бидний тодорхой мэдэхээр Агваан-Ишсамбуу нь “..зан үйл, уран зохиол, элдэв арга”-ын чиглэлээр 1 боть зохиол туурвисан¹⁷. Харин судлаач Р.Бямбаагийн сүүлд мэдээлснээр “Аяга цайны бага боть”, “Хоосон чанарын номын зүйл” ботийн гарчигт нэр нь дурдагдаагүй, давхардсан хэд хэдэн зохиолын нэр гарч байгааг тэмдэглээд, нийт 140 шахам бүтээл одоогоор олдож, бүртгэгдсэн байна. Эндээс үзэхэд, дан ганц Агваан-Ишсамбуу төдийгүй төвд хэлээр ном зохиол туурвисан монгол лам нарын зохиол бүтээлийн судалгааг тухайлбал ном судлалын үүднээс “одоо бүрэн боллоо, бүрдлээ”, гүн ухааны үүднээс “гүнзгийрүүлэн судлаад, танив, шавхав” гэж эцсийн байдлаар нэгтгэн дүгнэх нь нэг талаас ихээхэн бэрх, нөгөө талаас эртдэх гэмтэй болохыг бидэнд анхааруулж байна.

Агваан-Ишсамбуугийн намтарт холбогдох зарим мэдээ зөрүүтэй, цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна. Тухайлбал, түүний төрсөн газар, таалал болсон цаг хугацааны талаар судлаачид янз бүрээр тэмдэглэжээ. “Шар үсийг хөдөлгөгч” зохиолд “Халхын түшээт хан аймгийн Га /Гапэлдорж/ засгийн хошуу одоогийн Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Баянзүрхийн Ороох хэмээх газар”¹⁸, “Эсрүний авхайг мөшөөлгөсний эгшиг” зохиолд “...Халх зүүн аймгийн туслагч гүн Сономцэрэнгээр эзэлсэн газрын Бүрэг, Шар шувуутай хэмээх нутагт төрсөн”¹⁹ гэх зөрүүтэй мэдээ байна. Эл зөрүүтэй мэдээний талаар өмнө тэмдэглэсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэлээс сийрүүлбэл дараах болно. Эрдэмтэн судлаач Л.Хүрэлбаатар “Эрхэмсэг магтаалын цагаан лянхуа”-даа дээрх хоёр үзэлтийн аль алийг тэмдэглэсэн байдаг. Судлаач Ж.Дашдондог нь Баянзүрхийн Ороох гэдэг газар төрсөн гэж үзсэн бөгөөд тус газар 1997 онд, түүний мэндэлсний 150 жилийн ойгоор гэрэлт хөшөө босгосон нь өдгөө бий. Эрдэмтэн судлаач, гавж Ш.Сонинбаяр “хонин жилийн зуны дунд сарын шинийн нэгний төмөр луу өдрийн тахиа цагт...Баянзүрхийн Ороох

¹⁷ Гомбожав С. Монголчуудын түвд хэлээр зохиосон зохиолын зүйл, УБ., 1959. 36 тал

¹⁸ Шашныг тодруулагч эрдэнэ мэргэн бандида ламын нууцын намтартай барилдуулсан залбирал, сүжгийн шар үсийг хөдөлгөгч

¹⁹ Хүрэлбаатар Л. «Эрхэмсэг магтаалын цагаан лянхуа»-«Огторгуйн цагаан гарди». УБ., 1996, 101

хэмээх газар”²⁰ мэндэлсэн гэх мэдээг илтгэлдээ эш татсан байна. Судлаач Д.Даваасүрэн түүний төрсөн газрын тухай эх сурвалжуудын мэдээ зөрөөтэй байгааг дурдаад, “Шар үсийг хөдөлгөгч”-д буй мэдээг одоогийн Бүрэгхангай сумын төвөөс зүүн хойш, 2 дугаар багийн нутагт харьяалагдах тус газрыг Ороох гэх чандмалсан буйртай өвөлжөө байдаг”²¹ гээд зуны дунд морин сар хүртэл өвөлжөөнд суухгүй гэх үндэслэлээр дээрх мэдээг үгүйсгэж, харин “Эсрүний авхай” гэх номын төгсгөлийн шүлэгт буй хоёр дахь мэдээг баримтлан “...үргэлжилсэн их нуруу Бүрэг гэх газрын хувьд буй Шаршувуутай (эдүгээ Шувуут гэдэг) нь зуслан газар”²² мэндэлсэн улирал, цагийн үүднээс үзвэл, Агваан-Ишсамбуугийн төрсөн газар гэж үзэх боломжтой гэжээ. Бид дээрх мэдээ, тайлбар, судлаачдын байр сууринаас оюун дүгнэлт хийж, Агваан-Ишсамбуугийн мэндэлсэн газар нь Шувуут буюу Шувуутын голын сав газар гэдэг үзэлтийг дэмжиж байгаа болно.

Агваан-Ишсамбуугийн таалал болсон цаг хугацааны тухай мөн л харилцан адилгүй аман мэдээ бидэнд байна. Тухайлбал, Буриадын бандида хамба Дамба Аюушиев “1910-аад оны үед Алтанбулаг дахь Хиагтын зах дээр явж байсан” тухай мэдээг бидэнд ярьсан юм. Мөн эрдэмтэн М.Санждорж “Өнчин янзага, тарвага, хөгшин үнээ гурвын үг гэдэг хуучин зохиол” сэдэвт өгүүлэл, Германы монголч эрдэмтэн Вольтер Хейссикийн бичсэн Гэндэн мээрэн, Дорж мээрэн болон Агваан-Ишсамбуу нарын талаар бичсэн өгүүлэлдээ тус тус 1847 онд мэндлээд, 1906 юмуу, 1907 онд таалал болсон гэж үзсэн байна. Бас эрдэмтэн, гавж Ш.Сонинбаяр “Эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуугийн намтар судлалд” сэдэвт өгүүлэлдээ “судлаач Л.Хүрэлбаатар, Р.Бямбаа нар Агваан-Ишсамбуугийн таалал төгссөн оныг 1896 гэж адилхан бичсэн”-ийг тэмдэглээд, Шаддүвлин хийдийн даяанч лам Лувсангончогдоржийн зохиосон намтарт буй “Нархажодын оронд залрахад бэлтгэсэнээ залбирмой” хэмээсэн нэгэн мөрийн утганд шинжлэл хийгээд “энэ намтарын дотор мичин жилийн өвөл Нархажод бурхны нямба бүтээлийг гүйцээж цогчод цонхор өргөх үед алтан өнгөт ялаа нисэн ирж өмнө нь суусанд Ханд дагнисын оронд дагуулан барьсаны шинж тэмдэг болов уу”²³ гээд, дээрх тайлбарт буй мичин жилийг нийтийн тооллын 1896 он болохыг тодлон тэмдэглэсэн байна. Эндээс үзвэл, түүнийг хэзээ таалал болсон бэ гэдэг асуултад бүрэн дүүрэн хариулах боломж бага байна. Буриадын бандида хамба Дамба Аюушиеваас сонссон аман мэдээ бидний анхаарлыг зүй ёсоор татаж байгаа бөгөөд түүнийг тодруулах, магадлах талаар цаашид анхаарах нь зүйтэй юм.

Доктор Ш.Сонинбаярт хадгалагдаж буй, судлаач Р.Бямбаагийн 2012 онд хэвлүүлсэн “Жидорын хамба Агваанхайдүвийн хувилгаан шашныг гийгүүлэгч эрдэнэ мэргэн бандида Ишсамбуугийн намтар хийгээд сүмбүмийн бүрэн гарчиг оршивой” хэмээх “Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл цувралын VIII-д бүртгэсэн энэхүү “Sa mtha’ btsun pa ngag dbang ye shes bzang po gzhan la phan pa’i sdes rang lo nyer gsum pa’i steng du btsams pa’i lam rim khrid yig rtsom ‘phro zhes bya ba bzhugs so” [мон: Хязгаар газрын тойн Агваанишсамбуу бусдад туслахыг нэмэж өөрөө хорин гурван сүүдэр дээрээ зохиосон Бодь мөрийн хөтөлбөр бичиг хэмээх оршивой] (цаашид “Мөрийн зэргийн хөтөлбөр бичиг” гэнэ.) нэрт зохиолоо Агваан-Ишсамбуу 1870 онд зохиосон болохыг баримтад түшиглэн тодруулсан нь, нийтээр 1873-1895 оны хооронд зохиол бүтээлээ туурвиж байсан гэх үзэлтийг даруй гурван жилээр урагшлуулжээ. Энэ мэтээс үзэхэд, Агваан-Ишсамбуугийн намтар, түүний зохиол бүтээлийн судалгааны өнөөгийн байдалд эл хүрээний судлагдахууныг бүрэн судалж гүйцэв гэж бардаагаар хэлж, эцэслэн дүгнэх боломжгүй байгаа юм. Тиймд Агваан-Ишсамбууд холбогдох мэдээ баримтыг түүний амьдарч байсан нутаг орон, түүнийг багшид шүтэж асан нутаг хошууны байцаар сурвалжлах нь намтарт холбогдох тодорхойгүй байгаа дээрх зүйлсийг тодруулахад ач холбогдол өгнө гэж үзэж байна.

²⁰ Сонинбаяр Ш. Эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуугийн намтар судлалд-«Монголын соён гэгээрүүлэгч эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуу». УБ., 2012 он 158

²¹ Даваасүрэн Д. Бандида занабарагийн нэгэн залбиралд хийсэн ажиглалт-“Монголын соён гэгээрүүлэгч эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуу”. УБ., 2012 он 210

²² Даваасүрэн Д. Бандида занабарагийн нэгэн залбиралд хийсэн ажиглалт-“Монголын соён гэгээрүүлэгч эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуу”. УБ., 2012 он 210

²³ Сонинбаяр Ш. Эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуугийн намтар судлалд-«Монголын соён гэгээрүүлэгч эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуу». УБ., 2012 он 157

Агваан-Ишсамбуу нь буддын гүн ухааны зохиолууд бичсэн байна. Тухайлбал, түүний бодь мөрийн зэрэгт холбогдох зохиол бүтээлийн талаар Л.Хүрэлбаатар бээр Агваан-Ишсамбуу ламын зохиосон хоёр зүйл Бодь мөрийн зэргийн зохиол байгаа тухай 1975, 1996 онуудад судалгааны ажлуудаараа дамжуулан анх мэдээлжээ. Үүнд, “Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр.... Тодорхой зул” хэмээх зохиолын төгсгөлийн үг “..Сүргийн манлай хэмээгч арван тавдугаар равжүнгийн төмөр луу бөгөөд Манжийн хаан бадаргуулт төр ширээнд суусны долдугаар он, Монголын долдугаар сарын шинийн аравны өдөр халх Түшээт хан аймгийн гүн Сономцэрэнгийн нутаг Дашгэмпэл (Орхон голын ойролцоо) уулын ой доторх Хажод гүрханд зохиовой гэснээс үзэхэд уг номыг 1881 оны төмөр луу жил” болохыг тодруулан тэмдэглэсэн байдаг.

Эдгээрт үндэслэн Агваан-Ишсамбуу судлалд дараахь ажлуудыг эрчимжүүлэх, нэмж хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд :

1. Эрдэнэ мэргэн бандида Агваан-Ишсамбуугийн намтарт холбогдох аман мэдээг цуглуулж эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах, түүгээр намтарыг нь баяжуулах;
2. Агваан-Ишсамбуугийн намтар, бүтээлд холбогдох бичгийн эх сурвалжуудаар дамжуулан түүний намтар дахь тодорхойгүй зүйлсийг тодруулж нөхөх;
3. Түүний зохиосон монгол, төвд хэлт зохиол бүтээлийг тодруулах, судлах, агуулгыг нь нээн илрүүлэх;
4. Бүтээлүүдэд нь үндэслэн гүн ухааны үзлийг нь судалж гаргах
5. Тэдгээрээр дамжуулан Агваан-Ишсамбуугийн амьдарч байсан цаг үеийн нийгэм улс төрийн үзэл санааг тодруулах зэрэг болно.

Ингэснээр 19 дүгээр зууны монголчуудын сэтгэлгээний онцлогийг нээн илрүүлэхэд ач холбогдолтой болохын зэрэгцээ монгол сэтгэгчдийн бүтээлийн судалгаа баяжих ач холбогдолтой.

ABSTRACT

This paper will emphasize some issues for studying of the biography and works of Mongolian Buddhist master Agvaan-Ishsambu. He wrote many writings on Buddhist history, philosophy, didactic literature, poetry, the gradual path of enlightenment and rituals.

The researchers from different disciplines have studied his biography and works from distinctive approaches such as history, culture, philosophy, religious studies, linguistic and anthropology. The article will examine some arguments and perspectives of the researchers on his birthday and birthplaces, which mentioned in his writings and other texts.

Furthermore, this article suggests the more study need to clarifying the philosophical view of Agvaan-Ishsambu, social and political factors of his lifetime.

НОМ ЗҮЙ

1. С.Гомбожав. Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын зүйл. УБ.,1959.
2. Лувсангончогдорж. bsTan pa'I gsal byed 'er te ni mer gen pandita hu pil kan bla ma'I gsang ba'I mam thar dang 'brel ba'I gsol 'debs dad pa'I spu long gyo byed ces bya ba., түвд, гар бичмэл 17 хуудас судар.
3. Л.Хүрэлбаатар. Огторгуйн цагаан гардь. УБ., 1996.
4. Монголын соён гэгээрүүлэгч эрдэнэ мэргэн бандида Агваанишсамбуу. ЭШХ-ын эмхтгэл. УБ., 2012.
5. Зонхава Лувсандагва. Их бодь мөрийн зэрэг. орч. Т.Булган.УБ., 2004.